

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2021 оны 06 дугаар сарын 15

Рашаант

Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2021 онд дэвшүүлсэн зорилт, Засгийн газрын тогтоолоор батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх үндсэн үйл ажиллагааны зэрэгцээ Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн зөвлөмж чиглэлийг удирдлага болгон МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажил болон бүртгэлийн ажил үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах зорилтыг хангахад онцгойлон анхаарал хандуулан ажиллалаа.

Улсын бүртгэлийн хэлтэс хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах, улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах, улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга замаар улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах зэрэг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллав.

Мөн хэлтсийн нийт албан хаагчдад Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хуулийг чанд мөрдөн, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, үйлчилгээний стандартыг баримтлан ажиллахыг үүрэг болгон мэргэжлийн удирдлагаар ханган ажиллалаа.

Хэлтсийн 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны энэхүү тайланд хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулсан, байгууллагын стратеги зорилтыг хангах, нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээнд хамрагдсан болон хэлтсийн хэмжээнд хийгдсэн ажил, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нөхцөл боломжоор хангах, улсын бүртгэгч нарын хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээг нэгтгэн танилцуулж байна. Үүнд:

- Бодлого, шийдвэр, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт;
- Улсын бүртгэлийн хууль тогтоомж, стандартын хэрэгжилт;

- Удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын биелэлт;
- МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажил, зохион байгуулалт
- Улсын бүртгэлийн (иргэнийн, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн)

үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэх ажлын зохион байгуулалт;

- Бүртгэлийн хяналт;
- Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн сайжруулалт;
- Санхүү, төсвийн удирдлага, төлөвлөлт болон төсвийн гүйцэтгэл;
- Байгууллагын дотоод ажил, үйл ажиллагааг сурталчлах ажиллагаа;
- Байгууллагын албан хаагчийн сургалт, хөгжил, ёс зүй;
- Орон нутаг дахь хамтын ажиллагаа;

НЭГ. БОДЛОГО, ШИЙДВЭР, ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

1.1.1. Үндэсний төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлт:

1.1.2. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийн хэрэгжилт;

1.1.3. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

1.1.4. “Нэг иргэн-нэг бүртгэл” хөтөлбөрийн хэрэгжилт

1.1.5. “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөр

1.1.6. Хүний эрхийг хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.7 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.8 Терроризмтэй тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Дээрх төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулах ажилтан, албан хаагчийг жил бүр өөрчлөн түүний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Төсөл, хөтөлбөрийн биелэлтийг төсөл хөтөлбөр бүрээр гарган заасан хугацаанд тогтмол тайлагнаж байгаа болно.

ХОЁР. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ;

Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын нэгдсэн чуулганаар Улсын бүртгэлийн багц хууль /шинэчилсэн найруулга/-иудыг хэлэлцэн батлаж хэрэгжүүлснээс хойш даруй 2 жил гаруй хугацаа өнгөрч өнөө үеийн цахим орчны

хэрэглээ, өөрчлөлт шинэчлэлт нь хууль тогтоомжийг улам бүр боловсронгуй болгон шинэчилж цаг үетэй хөл нийлүүлэх шаардлагыг бий болгож байна. “Нэг иргэн, нэг бүртгэл” хөтөлбөр ч үүнд зорьж батлагдсан бөгөөд бүртгэлийн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлэх, бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй бөгөөд ил тод, нээлттэй болгохоор тусгасан стратегийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгосон нь жил бүр биелэлээ олж буйг дурьдахад таатай байна.

ГУРАВ. УДИРДЛАГААС ӨГСӨН ЧИГЛЭЛ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

3.1.Ерөнхий газраас болон бусад байгууллагаас ирүүлсэн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлтийн талаар:

Нэг. Иргэний бүртгэлийн чиглэлээр

1.1.Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 11/622 тоот “Чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн биелэлтийн талаар:

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 11/622 дугаар чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай албан бичиг, 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаартай Улсын бүртгэлийн хэлтсийн ББНШК-ын хурлын тэмдэглэлийн дагуу тус хэлтсийн бүртгэлийн үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийн хадгалах хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй, архивын санд хадгалах шаардлагагүй устгах баримтын жагсаалтын дагуу Иргэний үнэмлэх дахин олголтын анкет, бүртгэлийн дэвтэр 2013-2018 оны 66 хадгаламжийн нэгж 25598 хуудас, Шилжих хөдөлгөөний бүртгэлийн дэвтэр 1997-2015 оны 32 хадгаламжийн нэгж 725 хуудас, Шилжилт хөдөлгөөний ИУБ-22 маягт бүрдүүлбэрийн хамт 2014-2015 оны 14 хадгаламжийн нэгж 3463 хуудас, Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас лавлагаа олголтын бүртгэл 2012-2015 оны 11 хадгаламжийн нэгж 867 хуудас, Аймаг,сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2012 оны сонгуулийн баримт материал битүүмжлэлтэй 96 дугтуйтай сонгогчдын нэрийн жагсаалт, итгэмжлэгдсэн ажилтны гэрээ, нууцын баталгаа 475 хуудас, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны ээлжит сонгуулийн баримт материал битүүмжлэлтэй 200 ширхэг дугтуйтай сонгогчдын нэрийн жагсаалт, Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны сонгуулийн баримт материал битүүмжлэлтэй 319 ширхэг дугтуйтай сонгогчдын нэрийн жагсаалт, 71 ширхэг

ууттай бүртгэлийн хуудас, СНЖ хүлээлцэх акт 105 хуудас, сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулсан лавлагаа /бүрдүүлсэн материалын хамт/ 237 хуудас, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн баримт материал битүүмжлэлтэй 208 ширхэг дугтуйтай сонгогчдын нэрийн жагсаалт, 60 ширхэг ууттай бүртгэлийн хуудас, сонгогчдын нэрийн жагсаалт хүлээлцэх акт 105 хуудас, сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулсан лавлагаа /бүрдүүлсэн материалын хамт/ 270 хуудас. Нийт 1077 хадгаламжийн нэгж 31845 хуудас бүхий устгах баримт бичгийг 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Улсын бүртгэлийн нэгдсэн архивын БНШАЗК-ын дүрмийг баримтлан устгах баримтын аюулгүй ажиллагааг ханган ажилласан. Ямар нэгэн зөрчил гараагүй Баримт устгалын явцын ажиллагааг фото зургаар баримтжуулан холбогдох тайланг 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хэлтсийн даргын 1/312 тоот албан бичгээр УБЕГ-ын нэгдсэн архивт хүргүүлсэн мөн t.baigalmaa@burtgel.gov.mn цахим хаягаар хүргүүлж ажилласан.

1.2.Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 2/699 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн биелэлтийн талаар:

2021 оны 02 дугаар сарын 05-ны өдөр шинэчилсэн бүртгэлд хамрагдсан, 18 ба түүнээс дээш насны иргэдийн тоог баг тус бүрээр гарган Сумын ИТХ-д хүргүүлж 02 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн хэсгийг байгуулсан тухай тогтоолыг бүрэн хүлээн авч шалгасан. Баянхонгор аймаг 20 сумын хэмжээнд 102 хэсэг байгуулагдаж, 200 хүрэхгүй сонгогчтой Гурванбулаг сумын Пионер толгой, 5-р багийг Хөвийн ам, 4-р багтай, Жинст сумын Уу булан, 1-р багийг Цагаан ус, 4-р багтай, Хүрээмарал сумын Дэлгэрмөрөн, 5-р багийг Норовлин, 3-р багтай нэгтгэж сонгуулийн хэсэг байгуулах тухай тогтоол гарч, 20 сумын тогтоолын хуулбарыг 02 дугаар сарын 25-ны өдөр yanjinjargal@burtgel.gov.mn, sh.urtnasan@burtgel.gov.mn хаягаар явуулж, эх хувийг Иргэний улсын бүртгэлийн газарт 03 дугаар сарын 03-ны өдөр хүргүүлсэн.

1.3 Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 11/2612 тоот “Санал авах тухай” албан бичгийн биелэлтийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар шинэчлэн батлагдсан Архив, албан хэрэг

хөтлөлтийн тухай хуулийн 49.1 дэх хэсэгт “Төрийн архивт архивч, архив-судлаач, сан хөмрөгч, сэлбэн засагч, архивын баримтын хадгалалтын технологич, баримт ариутгагчаар ажиллаж байгаа төрийн албан хаагчид 10 жил тутамд нэг жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно” гэж заасан тус заалтанд дурьдсан шаардлагыг хангаж байгаа тул нэг удаагийн мөнгөн урамшууллыг 2022 оны төсөвт тусгуулах саналд архивчаар 10 дахь жилдээ ажиллаж байгаа талаарх холбогдох материалыг 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр t.baigalmaa@burtgel.gov.mn цахим хаягаар хүргүүлж ажилласан.

1.4.Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2021 оны 04 сарын 02-ны өдрийн 2/2330 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн биелэлтийн талаар

Баянхонгор аймгийн 20 сумын хэмжээнд 2021 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 09-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 607 иргэн шилжин ирсэн бүртгэл бүртгэгдэж, нийт хөтлөгдсөн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хяналтын улсын байцаагч С.Баярмаа нягтлан шалгаж, иргэний улсын бүртгэлийг алдаагүй зөв, бүрэн гүйцэт баталгаажуулж дуусгасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу 2021 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр шилжилт хөдөлгөөний бүртгэлийг зогсоон бүртгэлийн дэвтэр, үлдэгдэл үнэт цаасыг Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэст татан авч 2021 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 09-ны өдрийг хүртэлх хугацаанд хөтлөгдсөн нийт 607 шилжин ирсэн бүртгэлтэй 20 ширхэг дэвтэр, 1604 ширхэг үнэт цаасыг хэлтсийн даргад 04 сарын 19-ний өдөр хүлээлгэн өгч хадгалж, УБЕГ-ын даргын тушаалаар шилжилт хөдөлгөөний бүртгэлийг нээснээр нотлох баримт, бүртгэлийн дэвтрийг бүртгэгчдэд хүлээлгэн өгөөд байна.

1.5.Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 5/2985 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн биелэлтийн талаар:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэрүүлэгчдийн Хурлын тогтоолыг 05 дугаар сарын 06-ны өдөр хяналтын улсын байцаагч С.Баярмаа, иргэний улсын бүртгэлийн тасгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, улсын бүртгэгч Э.Адъяабаяр, улсын бүртгэгч Б.Бямбадулам нар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах журмын 2.6-д заасан мэдээллийг шалгаж зөрчил илрээгүй болно.

1.6. Баянхонгор аймгийн Төрийн архивын тасгаас 2021 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 2/14 дугаар албан бичгийн биелэлтийн талаар:

Тус албан бичгийн дагуу сумын Засаг даргын Тамгын газарт ажиллаж буй улсын бүртгэгч нарын 2021 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгуулах баримтын саналыг нэг бүрчлэн гаргаж жагсаалт үйлдэн тасгийн болон хэлтсийн даргад танилцуулж хэлтсийн албан тоотоор 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр аймгийн Төрийн архивын тасагт хүргүүлэн ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2020.12.28-ны өдрийн 5/10921 дугаар Иргэний улсын бүртгэлийн зөрчлийн тухай албан бичгийн дагуу 2021/01/04-ний өдөр илтгэх хуудсыг, мөн 2021/01/13-ны өдөр төлбөрийн асуудлын улмаас иргэний үнэмлэхээ авах боломжгүй 47 иргэний судалгааг, 2021/01/15-ны өдөр 100-аас дээш настны судалгааг, 2021/01/18-ны өдөр Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд санал, 2021/01/28-ны өдөр Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын төсөлд саналаа тус тус хүргүүлэн ажиллалаа.

Хагас жилийн байдлаар байгууллагын цахим шуудангаар ирсэн 26 дотоод албан бичиг, иргэний улсын бүртгэлийн газраас телеграммаар ирүүлсэн 78 удаагийн чиглэл зөвлөмжийн дагуу нийт улсын бүртгэгч нарт тухай бүр шуурхай мэдээлэл хүргэж, бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр

3.1. УБЕГ-ын даргын болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын бичгээр ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар:

- УБЕГ-ын даргын **2020 оны А/1172 дугаар тушаалаар** Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасан хаяж, үрэгдүүлсэн гэрчилгээг хүчингүйд тооцсон дүгнэлт гаргаж, шийдвэрлэх эрхийг хэрэгжүүлэхийг хяналтын улсын байцаагч нарт зөвшөөрсөний дагуу хаяж, үрэгдүүлсэн гэрчилгээг дахин олгохтой холбоотой мэдүүлгийг хяналтын улсын байцаагчид хүсэлтийн хамт танилцуулан, улмаар дүгнэлт гаргуулж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн өмчлөх эрхийн гэрчилгээг дахин олгох бүртгэлийг хийж байна. Тайлант хугацаанд **хяналтын улсын байцаагчийн 14 удаагийн дүгнэлтээр 14 гэрчилгээг дахин шинээр олгосон** байна.

- ЭХЭУБГ-ын даргын **2020 оны 7/9562 тоот** чиглэлийн дагуу “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд засвар өөрчлөлт

хийсэн тухай тэмдэглэл"-ийг загвар хүснэгтийн дагуу гаргаж сар бүр тайлагнадаг ба тайлант хугацаанд хяналтын байцаагчийн **5 дүгнэлтээр 56 хувийн хэрэг** бүртгэлийн мэдээллийг цахим санд засварлаж алдааг залруулсан байна.

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас 2021 оны 03 сарын 16-ны өдрийн 7/1707, 2021 оны 03 сарын 29-ны өдрийн 1/2215, 2021 оны 04 сарын 14-ны өдрийн 7/2734 тоот албан бичгүүдээр холбогдох чиглэл, зөвлөмж ирүүлсэнийг улсын бүртгэгч нарт танилцуулж, нэг мөр ойлгон хэрэглэх, хэрэгжүүлэх талаар аргачилсан зөвлөгөө, зөвлөмжийг өгч, холбогдох сургалтыг 3 удаа зохион байгуулав.

- Хаягжуулалтын тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгө, гудамж, талбайг хаягжуулах журмын хүрээнд шинэчилэгдсэн хаягаар хийгдсэн кадастрын зураг, аймаг, сумын ИТХ-ын тогтоолыг үндэслэн газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн хаяг өөрчлөлтийн бүртгэлийг хийсэн ба уг бүртгэлтэй холбоотой бүртгэл, судалгааг ЭХЭУБГ-т edkhourungu@burtgel.gov.mn хаягаар сар бүрийн 25-ны дотор хугацаанд хүргүүлж, танилцуулав.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ , ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар Хэлтсийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөөг 01 дүгээр сарын 29-ний өдөр 5 чиглэлээр 24 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2021 оны 02 дугаар сарын 05-ны өдөр шинэчилсэн бүртгэлд хамрагдсан, 18 ба түүнээс дээш насны иргэдийн тоог баг тус бүрээр гарган Сумын ИТХ-д хүргүүлж 02 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн хэсгийг байгуулсан тухай тогтоолыг бүрэн хүлээн авч шалгасан. Баянхонгор аймаг 20 сумын хэмжээнд 102 хэсэг байгуулагдаж, 200 хүрэхгүй сонгогчтой Гурванбулаг сумын Пионер толгой, 5-р багийг Хөвийн ам, 4-р багтай, Жинст сумын Уу булан, 1-р багийг Цагаан ус, 4-р багтай, Хүрээмарал сумын Дэлгэрмөрөн, 5-р багийг Норовлин, 3-р багтай нэгтгэж сонгуулийн хэсэг байгуулах тухай тогтоол гарч, 20 сумын тогтоолын хуулбарыг 02 дугаар сарын 25-ны өдөр yanjinjargal@burtgel.gov.mn, sh.urtnasan@burtgel.gov.mn хаягаар явуулж, эх хувийг Иргэний улсын бүртгэлийн газарт 03 дугаар сарын 03-ны өдөр хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалттай <https://election.burtgel.gov.mn/> цахим хуудсаар 2021/04/01-2021/05/13-ны өдрийн хугацаанд танилцан мэдээлэл зөрүүтэй гэж Баянхонгор

аймгийн хаягтай 16 иргэн /4 иргэн 2 удаа мэдээлэл ирүүлсэн/ ирүүлсний дагуу утсаар холбогдон асуудлыг тодруулж, холбогдох зөвлөгөөг өгч илтгэх хуудсыг хүргүүлэв.

	Шалтгаан			Нийт
	Хаяг зөрүүтэй	Хаяг дээр олон сонгогч бүртгэлтэй	Бусад /түр оршин суугаа газраа санал өгнө гэж ойлгосон/	
Баянхонгор	5 /1 иргэний мэдээлэл 2 удаа ирсэн/	5 /2 иргэний мэдээлэл 2 удаа ирсэн./	15 /1 иргэний мэдээлэл 2 удаа ирсэн.	25

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 28.1-д зааснаар сонгогчийн бүртгэлд бүртгэгдсэний дагуу саналаа өгөх талаар зөвлөгөө өгч, <https://election.burtgel.gov.mn/> хаягаар дахин нэвтэрч сонгогчийн мэдээллийг баталгаажуулууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотойгоор биечлэн гаргасан гомдол ирээгүй болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу 2021 оны 05 дугаар сарын 15-25-ны өдрийн хооронд сонгогчийн шилжилт хөдөлгөөний бүртгэлд Баянхонгор аймгийн 102 хэсэг дээр шилжсэн 764, шилжин ирсэн 763, нийт 1527 бүртгэл бүртгэгдэж лавлагаа гаргасан байна. Дээрх тоог ангилбал хуулийн 24.1-д заасан сонгогч шилжсэн-6, шилжин ирсэн-8, 24.2-т зааснаар шилжсэн-758, шилжин ирсэн 755 байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд сонгуулийн 102 хэсгийн хороонд нийт 102 итгэмжлэгдсэн ажилтан ажилласан ба үүнээс 28 итгэмжлэгдсэн ажилтан нь Улсын бүртгэлийн хэлтсээс 74 нь бусад төрийн байгууллагаас ажилласан байна. Итгэмжлэгдсэн ажилтан эрх зүйн сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр онлайнаар 1 удаа, эрх зүй, мэдээлэл технологийн сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 29-30 -ны өдөр танхимаар 1 удаа тус тус зохион байгуулж ажилласан.

Сонгуулийн санал авах өдрийн үйл ажиллагаа

2021 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Баянхонгор аймгийн 20 сумын 102 хэсгийн 102 итгэмжлэгдсэн ажилтан, Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй шуурхай баг болон хэлтсийн бусад 3

албан хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирц бүртгэлийн мэдээ авах цагийн хуваарийн дагуу 102 хэсгийн мэдээг ахлах нягтлан бодогч Г.Бат-Очир, улсын бүртгэгч Ё.Пүрэвдамба, улсын бүртгэгч Э.Адъяабаяр, улсын бүртгэгч А.Оюунсүвд нэгтгэн 11³⁵, 15⁰⁰, 22⁵⁸ цагуудад нэгтгэн хүргүүлж ажиллав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн 102 хэсгийн үйл ажиллагаанд ноцтой зөрчилгүй, гар ажиллагаанд шилжсэн хэсэг байхгүй, хэвийн явагдаж дууссан.

ТАВ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН (ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН) ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН ШУУРХАЙ, ЧАНАРТАЙ ХҮРГЭХ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ;


Хэлтсийн хамт олон холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, эрх зүйн бусад актууд болон байгууллагын үйлчилгээний стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчилж, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллалаа.

Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх эрх зүйн орчин, орчин үеийн мэдээлэл технологийн шаардлагад нийцсэн цахим үйлчилгээг хүргэх нөхцөл боломж улам бүр төгөлдөршиж байна.

5.1. Иргэний улсын бүртгэл:


2021 оны хагас жилийн байдлаар төрсний бүртгэл 845, үрчилсний бүртгэл 12, ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл 35, эцэг /эх/ тогтоосны бүртгэл 41, гэрлэсний бүртгэл 296, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 33, нас барсны бүртгэл 184, шилжин ирсний бүртгэл 621, үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл 132, Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд шинээр 492, 25, 45 насны сунгалт хийлгэсэн 900, иргэний үнэмлэх дахин захиалсан 327, иргэний үнэмлэх олголтийн бүртгэл 1294, төрсний гэрчилгээ дахин олгосон 168, гэрлэсний гэрчилгээ дахин олгосон 23, регистрийн дугаар өөрчилсөн 3, нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 17 нийт 5423 бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэн, баталгаажуулсан байна.

Иргэний бүртгэлийн төрлөөр нь ангилан графикаар харьцуулан харуулбал:



Тайлант хугацаанд нийт 3063 лавлагаа олгосноос иргэнд 2304, албан хэрэгцээнд 348 лавлагааг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан, мэдээлэл удирдах системд шалган, шаардлагатай тохиолдолд иргэний баримтын архиваас эх нотлох баримтыг татан авч тулгаж иргэдэд лавлагаа олгож байна.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудад 400 удаагийн албан бичгээр хандсан 414 иргэний лавлагаа мэдээллийг хугацаанд нь гарган өгч гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох үйл ажиллагаанд төрийн байгууллагуудын уялдаа холбоог ханган ажиллаж байна.



5.1.1 Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн албан бичиг

Хагас жилийн байдлаар 113 удаагийн албан бичгээр 525 иргэний улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулахаар, 5 удаагийн албан бичгээр төрсний бүртгэл 3, нас барсны бүртгэл 1, гэрлэсний бүртгэл 9, нийт 13 бүртгэлийг хүргүүлж иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүрэн тусгуулсан байна.

5.1.2 Нэрийн санд хаяггүй иргэдийг хаягжуулсан байдал

Төрсний бүртгэлд эхийн мэдээлэл тусгагдаагүй шалтгааны улмаас Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд байнга оршин суугаа хаягийн бүртгэлгүй 2004, 2005 онд төрсөн 15 иргэний хаягийг тусгуулсан. Мөн иргэний шинэчилсэн бүртгэлд

хамрагдаагүй байсан иргэн Д.Арвинболд /вй64053015/-ын оршин суугаа хаягийг тусгуулж биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгэсэн.

5.1.3.Цахим үйлчилгээ

2021 оны эхний хагас жилийн байдлаар үндэсний цахим үйлчилгээний систем E-Mongolia-аар захиалсан 69 иргэний үнэмлэх, 25 гадаад паспортыг хүлээн авч иргэнд нь олгоод байна. Улсын бүртгэлийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд цахимаар үйлчилгээ авах зөвлөгөө мэдээллийг иргэдэд байнга өгч ажиллаж байна.

5.1.4. Бусад ажлын талаар

Улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, түүнд зарцуулах цаг хугацааг хэмнэх зорилгоор Улсын бүртгэлийн хэлтсийн байранд, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газарт тус тус иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Тус аймгийн Баянхонгор сум нь 31516 хүн амтай 1 улсын бүртгэгч иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэн ажилладаг ба Улсын бүртгэлийн багц хууль хэрэгжиж, харьяалал харгалзахгүй бүртгэлийн үйлчилгээ авдаг болсонтой холбогдуулан ачаалал нь нэмэгдсэн. Энэ байдлыг харгалзан улсын бүртгэгч Б.Бямбадуламд биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл, иргэний үнэмлэх дахин захиалгын эрхүүдийг нээлгэж төрийн үйлчилгээний нэгдсэн төвд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байна.


Тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч У.Золзаяа нь хүүхэд асрах чөлөөтэй байгаа тул тасгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр улсын бүртгэгч Э.Адъяабаяр хавсран гүйцэтгэж байна. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл зөвлөмж, албан бичгийг хүлээн авч тасаг тусдаа бүртгэл хөтлөн тухай бүр нь хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн тасгаас иргэний улсын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийг нийт улсын бүртгэгч нарт утсаар болон цахимаар /хэлтсийн хаалттай групп /дамжуулан хүргэж, танхимын сургалт 6 удаа, цахим сургалт 8 удаа, 103 удаа хэлтсийн дотоод бүлгэмд мэдээлэл, зөвлөмжийг хүргэсэн байна.

5.1.5.Иргэний улсын бүртгэлийн архивын чиглэлээр

Иргэний баримтын архивын хувийн хэргийн санд нийт **116328** иргэний хувийн хэрэг хадгалагдаж байна.

Улсын бүртгэгч нараас 2021 оны эхний хагас жилийн байдлаар иргэний улсын бүртгэл хөтөлсөн нийт **4501** ширхэг ИУБ маягтыг “Архивт маягт хүлээлцэх бүртгэл” болон нэрийн жагсаалтын хамт хүлээн авч цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан, архивт хүлээн авч хувийн хэргийн нэгдсэн санд нэг бүрчлэн байршуулж хувийн хэргийн баяжилтыг хийж ажиллалаа. Үүнийг доорх графикаар харуулвал:



Эхний хагас жилийн байдлаар өөр аймаг, хотруу бүр мөсөн шилжин явсан нийт 68 иргэний хувийн хэрэг, хаатр маягтыг жагсаалтын хамт хэлтсийн даргын албан бичгээр хүргүүлж ажилласан байна. Тухайлбал:

1. Улаанбаатар хотруу 2 иргэний хувийн хэрэг
2. Өмнөговь аймагруу 2 иргэний хувийн хэрэг
3. Дархан аймагруу 2 иргэний хувийн хэрэг
4. Орхон аймагруу 10 иргэний хувийн хэрэг
5. Төв аймагруу 13 иргэний хувийн хэрэг
6. Сүхбаатар аймагруу 2 иргэний хувийн хэрэг
7. Өвөрхангай аймагруу 15 иргэний хувийн хэрэг
8. Говь-Алтай аймагруу 14 иргэний хувийн хэрэг
9. Булган аймагруу 2 иргэний хувийн хэрэг
10. Ховд аймагруу 2 иргэний хувийн хэрэг
11. Хөвсгөл аймагруу 1 иргэний хувийн хэрэг
12. Хэнтий аймаг руу 4 иргэний хувийн хэрэг

Мэдээллийн санд мэдээлэл нь зөрүүтэй иргэдийн хувийн хэрэг, болон архивын цаасан эх нотлох баримттай тулгах шаардлагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтан Хэлтсийн дарга, Тасгийн дарга, Хяналтын улсын байцаагч,

Улсын бүртгэгч нарт “Архиваас хувийн хэрэг захиалах хуудас”-аар нийт 93 иргэний хувийн хэрэг, “Архиваас бүртгэлийн дэвтэр захиалах хуудас”-аар 58 ширхэг бүртгэлийн дэвтрийг архивын сангаас гаргаж, буцаан хүлээн авч санд байршуулан ажилласан байна.


Иргэний улсын бүртгэгч нараас 2020 оны бүртгэлийн дэвтэр, бүртгэл хийхэд бүрдүүлсэн баримт бичгийг архивт хүлээн авахдаа баримтын үдэлт, дугаарлалт, нүүр, ашиглалтын хуудас, дотоод товъёг, баталгааны хуудас, бүртгэгчийн гарын үсэг зэргийг нягтлан шалгаж нийт **253** ширхэг хадгаламжийн нэгжийг “2020 оны бүртгэл, нотлох баримт хүлээлцэх” жагсаалтаар архивт хүлээн авч хаягжуулж, хадгаламжийн нэгж үүсгэн тавиурт байршуулан ажиллалаа.

Журмын дагуу сар бүрийн 25-ны өдөр иргэний бүртгэлийн архивын мэдээг гарган Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн нэгдсэн архивт эхний хагас жилийн байдлаар 5 удаа хэлтсийн даргын албан тоотоор хүргүүлсэн байна.

5.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэл:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт **420** өргөдөл хүсэлт хүлээн авсан ба энэхүү ажиллагааны үр дүнд дараах **75** аж ахуйн нэгжийг шинээр улсын бүртгэлд бүртгэсэн байна.

Шинээр бүртгэгдсэн ААНБ-ын хүснэгтээр харуулвал:



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд дахь өөрчлөлтийн бүртгэл **108**, хуулийн этгээдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл **3** / ирсэн-2 явсан-1/, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас татан буугдсан бүртгэл **2** удаа бүртгэгдсэн байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийн улсын бүртгэлийн архив мэдээллийн сангийн баазаас холбогдох лавлагаа, мэдээллээр нийт **37** удаа үйлчилгээ үзүүлсэн байна.

Үүнд:

1.Иргэнд-2

2.Хуулийн этгээдэд-21

3.Төрийн байгууллагад-14

Улсын бүртгэлийн гэрчилгээг аж ахуйн нэгжүүдэд сольж шинээр дахин олгох бүртгэл нийт **20** удаа хийгдсэн байна.

Харин Хуулийн этгээдийн нэрийн баталгаажилтын бүртгэл-**74**, Хуулийн этгээдэд тамга, тэмдэгийн хяналтын дугаар олгох бүртгэл-**83**, Хуулийн этгээдээс хурааж авсан тамга, тэмдэгийн бүртгэл -**18** тус тус хийгдсэн ба холбогдох журмын дагуу архивт шилжүүлсэн.

Тайлант хугацаанд хийсэн бүртгэлийн үйл ажиллагаанаас 5410500 төгрөгийг тэмдэгтийн хураамжийг орон нутгийн дансанд, үйлчилгээний хөлс болох 37500 төгрөгийг байгууллагын орлогын дансанд тус тус төвлөрүүлэн ажилласан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас ирүүлсэн 6/346, 6/2938 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлүүдийг удирдлага болгон өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн УБЕГ-ын Хяналтын улсын ахлах байцаагч Ш.Уртнасангийн “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагын дагуу холбогдох зөрчлүүдийг арилган хугацаанд нь буюу 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр sh.urtnasan@burtgel.gov.mn цахим хаягаар хүргүүлэн ажилласан.

Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын чиглэлээр:

Хуулийн этгээдийн бүртгэлийн архивт нийт 2301 ширхэг хувийн хэрэг хадгалагдаж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б.Хүрэлчулуунаас Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/1050 дугаар тушаалын 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт шилжүүлсэн жагсаалт"-аар “ 76 ширхэг шинэ хувийн хэрэг, “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлсэн жагсаалт”-аар 146 ширхэг нотлох баримт материал хүлээн авч хувийн хэрэг тус бүрт нэгтгэн байршуулж хувийн хэргийн баяжилт, хаягжуулалт хийж ажилласан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс 2020 онд бүртгэл хийх явцад хөтлөгдсөн нийт 10 баримтыг архивт хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэн тавиурт байршууллаа.

5.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар:

Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь 2021 онд дэвшүүлсэн зорилт, Засгийн газрын тогтоолоор батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх үндсэн үйл ажиллагааны зэрэгцээ Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн зөвлөмж чиглэлийг удирдлага болгон Улсын бүртгэлийн багц хуулийг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарал хандуулан ажиллалаа.

Улсын бүртгэлийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах, улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах, улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга замаар улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах зэрэг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллав.

Нэг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, эрх зүйн бусад актууд болон байгууллагын үйлчилгээний стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчилж, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллалаа.

Тус зорилтын хүрээнд зохион байгуулсан, удирдан чиглүүлсэн ажлууд энэхүү тайлан (тасгийн)-д бичигдсэн зорилтуудтай уялдаж явагдсан тул тайлангийн дараа дараагийн хэсгээс уншиж танилцана уу.

Гэхдээ энд нэмэлт мэдээлэл болгон танилцуулахад, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хууль тогтоомжийг практикт хэрэглэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээл, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэвэл зохих асуудлын талаар судалгаа, дүгнэлт хийж, танилцуулан шийдвэрлүүлэх нь нэн тэргүүний асуудал байлаа. Энэ талаар манай тасгаас хийж хэрэгжүүлсэн ажлаас товч дурьдахад; Үүнд:

1. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахтай

холбоотойгоор 6 саналыг edkhourungu@burtgel.gov.mn хаягаар 2020 оны 12 сарын 28-нд хүргүүлсэн байна.

2. “Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааны заавар”-т холбогдох 12 саналыг edkhourungu@burtgel.gov.mn хаягаар хүргүүлсэн байна.

3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд гарч буй асуудлын талаар, тодруулбал, Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас эд хөрөнгийн эрхийг хязгаарласан, түдгэлзүүлсэн бүртгэл хийлгүүлэхдээ хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргаагүй, зөвхөн албан бичгээр эд хөрөнгийн эрхийг хязгаарлах, түдгэлзүүлэх бүртгэл хийлгүүлэхээр ирүүлдэг, харин нийслэл болоод бусад аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар уг албан бичгийг үндэслэн эд хөрөнгийн эрхийг хязгаарласан, түдгэлзүүлсэн бүртгэл хийж байгаа нь хуулийн нэг мөр ойлгож хэрэгжүүлэхгүй, хэрэглэхгүй байгаа талаар саналаа амаар илэрхийлж, холбогдох арга хэмжээ авч өгөхийг ЭХЭУБГ-ын даргад илэрхийлсэн болно. Гэхдээ уг саналыг өмнөх жилүүдэд удаа дараа тавьж байсан гэдгийг дурьдах нь зүйтэй болов уу.

4. Улсын бүртгэлийн хаягийн мэдээллийн санд манай аймгийн Эрдэнэцогт сумын 6 дугаар багийн нэр болох “Цагаан дэнж”-ийг оруулаагүй, мөн тус сумын 5 дугаар багийн нэр “Эрхэтхайрхан” гэхийг “Эрхэттамч” гэж буруу оруулсан алдаатай байгаагаас шалтгаалан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд тухайн сумын газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн бүрдэл дутуу бөгөөд буруу бүртгэгдэж байгааг Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-д нийцүүлэн засаж залруулах арга хэмжээ авхуулахаар Хэлтсийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1/60 тоот албан бичгээр ЭХЭУБГ-ын даргад хүсэлтээ хүргүүлсэн бөгөөд УБЕГ-аас сонгуулийн үйл ажиллагаа дууссаны дараа авч хэлэлцэн шийдвэрлэх тухай хариуг өгсөн болно.

5. Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас 2021 оны 03 сарын 16-ны өдрийн 7/1707, 2021 оны 03 сарын 29-ны өдрийн 1/2215, 2021 оны 04 сарын 14-ны өдрийн 7/2734 тоот албан бичгүүдээр холбогдох чиглэл, зөвлөмж ирүүлснийг улсын бүртгэгч нарт танилцуулж, бүртгэлийн үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллаж байна.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

1.1.Ерөнхий газраас болон бусад байгууллагаас ирүүлсэн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлтийн талаар:

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 08 дугаарт дотоод албан бичгээр ирүүлсэн “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг цахимжуулах явцад ангилан ялгаж, тусгаарласан баримтын судалгаа болон мэдүүлгийн үлдэгдэл нөөцийн талаарх судалгаа”-г хавсралтын дагуу тасгийн хамт олон архивч Д.Отгонсүрэнтэй хамтран гаргаж Хэлтсийн даргын 2021 оны 01 сарын 20-ны өдрийн 1/45 тоот албан бичгээр edkhourungu@burtgelgov.mn хаягаар заасан хугацаанд хүргүүлсэн болно.

- Тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын ашиглаж буй скайнерын судалгаа”-г ирүүлэх тухай ЭХЭУБГ-аас 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн дотоод албан бичгийн дагуу холбогдох судалгааг Тасгийн дарга П.Бүжинлхам гаргаж заасан хугацаанд нь edkhourungu@burtgelgov.mn хаягаар хүргүүлсэн. Үүний үр дүнд УБЕГ-аас Canon DR-B260 маркийн хурдны скайнер өгсөн ба уг скайнерыг тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч албан хэрэгцээнд ашиглаж эзэмшиж байгаа болно.

1.2. УБЕГ-ын даргын болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын бичгээр ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар:

- УБЕГ-ын даргын **2020 оны А/1172 дугаар тушаалаар** Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасан хаяж, үрэгдүүлсэн гэрчилгээг хүчингүйд тооцсон дүгнэлт гаргаж, шийдвэрлэх эрхийг хэрэгжүүлэхийг хяналтын улсын байцаагч нарт зөвшөөрсөний дагуу хаяж, үрэгдүүлсэн гэрчилгээг дахин олгохтой холбоотой мэдүүлгийг хяналтын улсын байцаагчид хүсэлтийн хамт танилцуулан, улмаар дүгнэлт гаргуулж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн өмчлөх эрхийн гэрчилгээг дахин олгох бүртгэлийг хийж байна. Тайлант хугацаанд хяналтын улсын байцаагчийн **14 удаагийн дүгнэлтээр 14 гэрчилгээг дахин шинээр олгосон** байна.

- ЭХЭУБГ-ын даргын **2020 оны 7/9562 тоот** чиглэлийн дагуу “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд засвар өөрчлөлт хийсэн тухай тэмдэглэл”-ийг загвар хүснэгтийн дагуу гаргаж сар бүр тайлагнадаг ба тайлант хугацаанд хяналтын байцаагчийн **5 дүгнэлтээр 56 хувийн хэрэг** бүртгэлийн мэдээллийг цахим санд засварлаж алдааг залруулсан байна.


- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас 2021 оны 03 сарын 16-ны өдрийн 7/1707, 2021 оны 03 сарын 29-ны өдрийн 1/2215, 2021 оны 04 сарын 14-ны өдрийн 7/2734 тоот албан бичгүүдээр холбогдох чиглэл, зөвлөмж

ирүүлсэнийг улсын бүртгэгч нарт танилцуулж, нэг мөр ойлгон хэрэглэх, хэрэгжүүлэх талаар аргачилсан зөвлөгөө, зөвлөмжийг өгч, холбогдох сургалтыг 3 удаа зохион байгуулав.

- Хаягжуулалтын тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгө, гудамж, талбайг хаягжуулах журмын хүрээнд шинэчилэгдсэн хаягаар хийгдсэн кадастрын зураг, аймаг, сумын ИТХ-ын тогтоолыг үндэслэн газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн хаяг өөрчлөлтийн бүртгэлийг хийсэн ба уг бүртгэлтэй холбоотой бүртгэл, судалгааг ЭХЭУБГ-т edkhourungu@burtgel.gov.mn хаягаар сар бүрийн 25-ны дотор хугацаанд хүргүүлж, танилцуулав.

1.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд мөрдөгддөг хууль тогтоомж, чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажлын уялдаа холбоотой хамтран ажилладаг байгууллагатай харилцан мэдээлэл солилцож, хууль тогтоомжийг нэг мөр ойлгох, сурталчилан таниулсан байдал.

Хэлтсийн даргын **2021 оны 01 сарын 26-ны өдрийн 1/72 тоот албан бичгээр** аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт Хаягжуулалтын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой дагалдан гарсан



журам, бусад хууль тогтоомжийг нэг мөр ойлгон дагаж мөрдөх, хэрэглэх, хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хамтран ойлголцож ажиллах, кадастрын бүртгэл болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн суурь зарчим болох “Бүртгэл үнэн зөв, бодитой, хэрэгжихүйц байх” зарчмыг болон хуулийн хэрэгжилтийг хангаж хамтран ажиллах талаар албан хүсэлтийг илгээхийн зэрэгцээ хаягийн бүртгэлийг хөтлөхдөө гаргаж буй алдааг дахин давтахгүй байх анхааруулгыг давхар өгөв.

Хоёр. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар:

Тайлант хугацаанд буюу 2020 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 05-ныг хүртэлх хугацаанд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн нийт 5683 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэснээс газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэл 2826, газар өмчлөх эрхийн улсын бүртгэл 1948, газар эзэмших эрхийн улсын бүртгэл 909 бүртгэгдсэн байна. Харин боловсруулалтанд хүлээгдэж буй 11

мэдүүлэг, боловсруулалтад буцсан буюу бүртгэл хийхээс татгалзсан бүртгэл 43 бүртгэл байна.


Анхны бүртгэл 361, гэрээний эрхийн бүртгэл 355, барьцааны эрхийн бүртгэл 3629, эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэл 309, лавлагаа, хуулбар 42 бүртгэгдсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн үйлчилгээний төрлөөр нь ангилвал;

1. Газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, эзэмших эрхийн бүртгэл:

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг анх удаа бүртгүүлж баталгаажуулах бүртгэл **нийт 279**, үүнээс шинээр баригдсан орон сууцны өмчлөх эрхийг баталгаажуулах бүртгэл **105**, Төрөөс худалдаж авсан үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг баталгаажуулах бүртгэл **1**, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг анх удаа бүртгүүлэх бүртгэл **170**, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ, хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх бүртгэл **3** тус тус бүртгэгдсэн байна.

Харин газар өмчлөх, эзэмших эрхийг анх удаа баталгаажуулах бүртгэл **991**, үүнээс төрөөс үнэгүй хувьчилсан газрын өмчлөх эрхийг баталгаажуулах бүртгэл **81**, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салснаар шинэ бүртгэл үүсгэх бүртгэл **1**, газар эзэмших, ашиглах эрхийг анх удаа бүртгүүлж баталгаажуулах бүртгэл **909** бүртгэгдсэн байна.



2. Газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн гэрээний эрхийн улсын бүртгэл:

а/. Үл хөдлөх эд хөрөнгө: Худалдах, худалдан авах гэрээ 117, бэлэглэлийн гэрээ 3, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх хэлцэл 19, өмчлөгч өөрт ногдох хэсгээ бусад өмчлөгчид бэлэглэх гэрээ 9, өмчлөгч өөрт ногдох хэсгээ бусад өмчлөгчид худалдах гэрээ 1, өмчлөгч өөрт ногдох хэсгээс бэлэглэх гэрээ 5, хамтран өмчлөгч өөрчлөгдөх хэлцэл 27, өмчлөгчийн үүсгэн байгуулсан хуулийн этгээдээс иргэнд, иргэнээс үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн өмчлөлд өмчлөх эрх шилжүүлэх бүртгэл 4 тус тус бүртгэгдсэн байна.

Мөн Барьцаалбартай барьцааны гэрээ 714, барьцаалбаргүй барьцааны гэрээ 741, барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах гэрээ 83 барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах гэрээ 35, барьцааны гэрээ дуусгавар болох бүртгэл 852, барьцааны үүргийн зарим хэсэг дуусгавар болох бүртгэл 11 тус тус бүртгэгдсэн байна.

б/. Газар: Худалдах, худалдан авах гэрээ 102, бэлэглэлийн гэрээ 11, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 22, хамтран өмчлөгч өөрчлөгдөх хэлцэл 27, өмчлөгч өөрт ногдох хэсгээс бэлэглэх гэрээ 1, өмчлөгч өөрт ногдох хэсгээ бэлэглэх гэрээ 7 тус тус бүртгэгдсэн байна.


Мөн барьцаалбаргүй барьцааны гэрээ 749 барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах гэрээ 37, барьцааны гэрээ дуусгавар болох бүртгэл 670, барьцааны үүргийн зарим хэсэг дуусгавар болох бүртгэл 7 тус тус бүртгэгдсэн байна.

3. Бусад бүртгэл:

а/. Үл хөдлөх эд хөрөнгө:

Эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх бүртгэл 49, эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх бүртгэл 61, өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салснаар хэмжээ өөрчлөгдөх бүртгэл 1, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 61, эд хөрөнгийн үнэ, өмчлөгчийн овог, нэр, регистр өөрчлөгдөх бүртгэл 4, үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох бүртгэл 3 тус тус бүртгэгдсэн байна.

б/. Газар: Эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх бүртгэл 137, өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар хэмжээ өөрчлөгдөх бүртгэл 1, өмчлөгчийн овог нэр регистрийн дугаар өөрчлөлтийн бүртгэл 3, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 41, газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх бүртгэл 1, үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох бүртгэл 5, гэмтээсэн гэрчилгээ шинээр олгох 1 тус тус бүртгэгдсэн байна.



Хаягжуулалтын хуулийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн хаяг шинэчлэгдсэнтэй холбоотойгоор хаяг өөрчлөлтийн бүртгэл нийт 258 бүртгэл бүртгэгдсэн байна.

4. Лавлагаа, хуулбар:

Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой лавлагаа 22, газар өмчлөх эрхийн бүртгэлтэй холбоотой лавлагаа 4, архивын лавлагаа болох эд хөрөнгөтэй эсэх, эд хөрөнгийн түүхчилсэн лавлагаа 18 нийт 48 лавлагаа олгож, эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой нотлох баримтын хуулбар 16 мэдүүлгээр 16 хуудас нотлох баримтыг олгосон байна.

5. Гэрчилгээ олголт:

- Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбогдуулан газар өмчлөх эрхийн гэрчилгээ 442, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээ 583, нийт 1025 гэрчилгээ бичиж олгосон байна.

- Мөн хувийн хэрэг бүртгэлийг хаах 24 мэдүүлэг бүхий нотлох баримтыг цахим сантай тулган хүлээн авч, хуулийн хугацаанд ЭХЭУБГ-т хүргүүлж, шийдвэрлүүлсэн байна.

- Шинээр баригдсан орон сууцны жагсаалт, тухайн орон сууцны өмчлөх эрхийг нотолсон баримт бичгийг тасгийн дарга хянасны дараагаар хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагчаар давхар хянуулан үндсэн баримтын хуулбар хувийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт цаасан баримтын нэгж үүсгэн хадгалж байна.

- Тайлант хугацаанд хийсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт үйлчилгээний хураамж болох 145.101.306 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 2.000.602 төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны орлого 101.987.123 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Сумдын улсын бүртгэгч нар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдүүлгийг хүлээн авч нилээдгүй гаршиж байгаа ба тайлант хугацаанд сумдын улсын бүртгэгч нараас нийтдээ **299 мэдүүлэг** ирүүлэн шийдвэрлүүлсэн байна

Гурав. Эд хөрөнгийн бүртгэлийн архивын талаар:

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 2021 оны 05 сарын 25-ны байдлаар 20633 хувийн хэрэг хадгалагдаж байгаагаас газар өмчлөх эрхийн бүртгэлийн хувийн хэрэг 9493, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хувийн хэрэг 8232, харин газар эзэмших ашиглах эрхийн 2908 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Тайлант хугацаанд шинээр үүссэн 780 хувийн хэрэг хүлээн авч, 3958 хувийн хэрэгт баяжилт хийгдсэн байна.

Мөн улсын бүртгэгч нараас нийт 4738 бүртгэл маягтыг архивт хүлээлгэн өгсөн байна. Үүнээс эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн анхны бүртгэл хийгдсэн шинэ хувийн хэрэг 780, үйлчилгээ хийгдсэн /А,Б-1,2/ буюу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн маягт, нотлох баримт 3958 ширхэгийг эд хөрөнгийн тасгийн дарга, улсын бүртгэгч нараас бүртгэлийн нотлох баримт, маягтыг архивт хүлээн авахдаа “Архивт хүлээлгэн өгөх бүртгэлийн дэвтэр”-ээр хүлээн авч нэг бүрчлэн хувийн хэрэгт нэгтгэн байршуулж хувийн хэргийн баяжилтыг хийж ажилласан байна.

Мэдээллийн санд хувийн хэргийн дугаарлалт, үйлчилгээний төрөл зөрүүтэй орсон архивын цаасан эх нотлох баримт үзэх шаардлагатай хувийн хэргийг Эд хөрөнгийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч, Хяналтын улсын байцаагч, улсын бүртгэгч нараас “Архиваас хувийн хэрэг захиалах хуудас”-аар захиалга авч нийт 56 хувийн хэрэг гаргаж, буцаан хүлээн авч хувийн хэрэг гарсан болон хүлээн авсан он, сар, өдрийг бүртгэн захиалгын хуудсыг хаалт хийн хувийн хэргийг санд буцаан байршуулсан байна.

Харин 2021 оны 4 сараас эхлэн газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэлийн хувийн хэрэг үүсгэж хадгаламжийн нэгж бий болгохгүй болсонтой холбоотойгоор газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэлийн дугаар олгосоныг батлах маягтыг цахимаас хэвлэн авч 250 хуудастай хадгаламжийн нэгж үүсгэхээр болсон байна.

Хувийн хэрэг бүртгэл хаахтай холбоотой УБЕГ-ын даргын 9 тушаал гарсан ба эдгээр тушаалын дагуу 24 хувийн хэрэг бүртгэлийг хаах бүртгэлийг бүртгэн баталгаажуулсан байна.

Долоо. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хяналтын талаар:

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг өдөр тутам цахимжуулах ажил хийгдэж байгаа ба цахимжуулалтыг үнэн зөв, чанартай гүйцэтгэж байх талаар улсын бүртгэгч нарын өдөр тутам бүртгэн цахимжуулсан бүртгэлийг давхар хянан ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар хувийн хэрэгт авагдсан мэдүүлгийн дараалал буруу оруулж цахимжуулсан, нотлох баримтыг хооронд нь хольж зөрүүтэй скайнердсан, нотлох баримтын хуудсыг алдаатай дугаарласан, огт цахимжаагүй буюу цахим санд ороогүй гэх зэрэг шалтгааны улмаас 56 хувийн хэргийн буцаалтыг хийлгүүлж дахин цахимжуулах ажил хийлээ.

Харин Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг буюу цаасан суурьт баримтыг цахим мэдээллийн сантай тулгах ажлыг 2021 оны 4,5 сард хийхээр төлөвлөсөн байсан боловч Засгийн газраас бизнес эрхлэгчдийг дэмжин зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжсэнтэй холбоотойгоор ажлын ачаалал огцом нэмэгдэж, бүртгэлийн үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдсэний улмаас тус ажлыг төлөвлөсөн хугацандаа хийж амжаагүй хэдий ч 6, 7 сард хийхээр төлөвлөж байна.

Эд хөрөнгийн газрын даргаас ирүүлсэн чиглэлийн дагуу 50.000.000 төгрөгөөс дээш үнийн дүнтэй барьцааны гэрээний бүртгэлийг **“Эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгэх эсэх тухай дүгнэлтийн хуудас”**-аар тасгийн дарга, түүний эзгүйд хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагчид танилцуулан холбогдох дүгнэлт, саналыг авч зохих бүртгэлийг хуулийн шаардлагад нийцүүлэн хөтлөж байна.

Тайлант хугацаанд 288 ширхэг **“Хэд хэдэн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан гэрээ, ипотека болон шаардах эрх шилжүүлэх гэрээг улсын бүртгэлд бүртгэх хяналтын хуудас”**-аар 50.000.000 саяаас дээш үнийн дүнтэй 535 үл хөдлөх эд хөрөнгө барьцаалагдсан Барьцааны гэрээний бүртгэл танилцуулагдаж, зохих шийдвэр, зөвлөмжийн дагуу бүртгэгдсэн байна.

“Хяналтын хуудас”-аар танилцуулагдан бүртгэгдэж байгаа бүртгэлийг тасгийн дарга хяналтаа авч, давхар бүртгэдэг ба энэ нь бүртгэлийн дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа нэгэн хэлбэр юм.

ЗУРГАА. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ;

6.1. Бүртгэлийн хяналт хийсэн талаар:

2021 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн байдлаар бүртгэлийн хяналтын чиглэлээр дараах үйл ажиллагаа хийж гүйцэтгэсэн байна.

Нэг. 2021 оны 05 дугаар сарын 25-ны байдлаар бүртгэлийн төрөл тус бүрд хяналт тавьсан байдал.

Иргэний бүртгэлийн чиглэлээр 1850

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 185

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 98

Архивын чиглэлээр 415 бүртгэлд хяналт тавьж , нийтдээ **2548** бүртгэлд хяналт тавьсан байна.

Хоёр.2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт шалгалт хийгдсэн байдал.

2021 оны эхний хагас жилд төлөвлөгөөт шалгалт-3, гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт-1 хийгдсэн байна. 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу говийн бүсийн Баянлиг, Баянговь, Богд, Жинст, Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Хангайн бүсийн Заг, Жаргалант, Галуут, Баян-Овоо, Гурванбулаг сумдын улсын бүртгэгч нарын 2021 оны эхний хагас жилийн 350 бүртгэлд хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар нотцой зөрчил дутагдал илрээгүй болно. Улсын бүртгэл хөтлөхтэй холбоотой арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.

Гурав. Иргэн, Эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр илрүүлсэн зөрчил. Иргэний бүртгэл -48, Эд хөрөнгийн чиглэлээр -10, Хуулийн этгээд -5, Улсын бүртгэлийн архивын /иргэний/ чиглэлээр -63 Нийт **126** зөрчил илрүүлснийг тухай бүр залруулж ажиллалаа.

Дөрөв. Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын талаар. Зөрчлийн тухай хуульд заасны дагуу нийт **338** иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнээс 337 иргэн, 1 хуулийн этгээдэд шийтгэл ногдуулж, улсын төвөст **7 970 000** төгрөгийн орлого төвлөрүүлж, харин 31 иргэний өргөдлийн материалыг **татгалзаж** шийдвэрлэсэн байна. Зөрчлийн тухай хуульд заасан Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу Прокурорын байнгын хяналтан дор явуулж байна.

Тав. Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт.

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон бүртгэлийн зөрчил дутагдал гаргахгүй байхад анхаарч зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын

бүртгэлийг хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв бүртгэл хөтлөхийг зорилтоо болгон ажиллаж байна.

2021 оны 05 сарын 25-ны өдрийн байдлаар Хяналтын улсын байцаагчийн нийт 98 дүгнэлт гаргаснаас иргэний бүртгэлийн чиглэлээр гарсан дүгнэлтүүдийг хүснэгтээр харуулвал. Үүнд:

№	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
1	Нөхөн бүртгэх тухай	1
2	Бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах тухай	49
3	Бүртгэл хийх тухай	0
4	Бүртгэл хүчингүй болгох тухай	6
5	Регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай	4
6	Зөрчил арилгах тухай	14
7	Эд хөрөнгийн бүртгэлийн талаар	10
8	Хуулийн этгээдийн бүртгэлийн талаар	2
9	Бүртгэл сэргээх	1
	Нийт	87

Бүртгэлийн төрлөөр ангилвал.

№	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
1	Иргэний бүртгэл	75
2	Хуулийн этгээдийн бүртгэлийн талаар	2
3	Эд хөрөнгө	10
	Нийт	87

Зургаа. Хяналтын улсын байцаагчаас гарсан

№	Хяналтын улсын байцаагчийн	тоо
1	Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	87
2	Хяналтын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсаар	307
3	Хяналтын улсын байцаагийн мэдэгдэл	0
4	Хяналтын улсын байцаагчийн акт	0
5	Хяналтын улсын байцаагчийн албан шаардлага	0
	Нийт	394

Долоо. 2020.12.15- 2021.05.25-ны өдрийн байдлаар иргэн хуулийн этгээдээс байгууллагын бичиг хэрэгт ирүүлсэн нийт 75 өргөдөл, гомдол хүлээн авснаас 65 өргөдлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр, 5 өргөдлийг албан тоотоор, 5

өргөдлийг шийдвэрлэхээр шалгаж байна. Мөн байгууллагын /тус хэлтсийн/ эрх бүхийн албан тушаалтны 25 хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

Мөн 2021 оны 05 сарын 25-ны өдрийн байдлаар бүртгэлийн хяналтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын мэдээг Хяналт шалгалтын газарт 5 удаа хугацаандаа хүргүүлсэн, Аймгийн Прокурорын газарт зөрчлийн хэрэг бүртгэлтийн мэдээг 5 удаа тогтоосон хугацаандаа хүргүүлсэн, мөн зөрчлийн материалыг 7 хоног бүрийн даваа, баасан гарагуудад хүргүүлж /5 удаа/ хянуулсан, хэлтсийн нягтлан бодогчид маягт үнэт цаасны мэдээ /шийтгэлийн хуудасны мэдээ/ -г 5 удаа хугацаандаа өгч ажилласан байна.

ДОЛОО. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛАХ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙН САЙЖРУУЛАЛТ;

7.1. Программ хангамжийн талаар:

- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох” төслийн хүрээнд бүртгэлийн байгууллагын сум, хорооны нэгжийг онлайн сүлжээнд холбох ажил бүрэн дууссан.

УБЕГ-аас иргэний улсын бүртгэлийн шинэчилсэн программыг ажиллагаанд оруулж сумдын улсын бүртгэгчид дадлага хийн ажиллаж холбогдох санал болон дадлага хийсэн тайланг илтгэх хуудсаар хүргүүлсэн болно.

Техник, тоног төхөөрөмжийн талаар:

2021 оны хагас жилийн байдлаар тус хэлтэст УБЕГ-аас Dell-7030 i3 үзүүлэлт бүхий иж бүрэн 1 ширхэг компьютер, Epson ds-530 маркын 1 үйлдэлт скайнер 1 ширхэг, canon DR-M260 маркын 1 үйлдэлт скайнер 2 ширхэг, нийт 3 ширхэг скайнерыг татан авч бүртгэгч нарт хүлээлгэн өгч ажиллагаанд оруулснаар бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх бас нэг нөхцөл бүрдээд байна.

Найм. САНХҮҮ, ТӨСВИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2021 оны 06 сарын 15-ны байдлаар улсын төсвөөс 284.691.1 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч цалин хөлсний зардалд 192.884.7, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 25.190.2, гэрэл цахилгааны зардалд 929.5, түлш халаалтын зардалд 22.240.0, цэвэр бохир усны зардалд 388.6, бичиг хэргийн зардалд 1.581.0, тээвэр шатахууны зардалд 1.377.0, шуудан холбооны зардалд 707.5, хог хаягдал зайлуулах зардалд 51.0, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 495.0, багаж техник хэрэгслийн зардалд 106.0,

хөдөлмөр хамгааллын хэрэглэлийн зардалд 36,8, урсгал засварын зардалд 60.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 305.0, тээврийн хэрэгслийн татварын зардалд 116.5, тээврийн хэрэгслийн оношлогооны зардалд 22.0, бараа үйлчилгээний бусад зардал /2021 оны Монгол Улын Ерөнхийлөгчийн сонгууль/-д 24.001.2 мянган төгрөг зарцуулж улсын төсвийн орлогын дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 97.540,8 мянган төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна.

УБЕГ-ын Санхүү, аж ахуй хэлтсээс 2.381.5 мянган төгрөгийн үнэт цаас, хангамжийн материалыг хүлээн авч 3.647.8 мянган төгрөгийн үнэт цаас, хангамжийн материалд хөдлөл өөрчлөлтөөр бүртгэн сар бүр үнэт цаасны тайлан няравын тайланг гаргуулан авч хэвшсэн.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж сар, улирал, хагас жилийн тайланг УБЕГ-ын Санхүүгийн хэлтэст 5 удаа, Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэст сар бүр, Татварын хэлтэст улирал бүр тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж баталгаажуулан харилцагч байгууллагуудтэй тооцоо нийлж өглөг авлага үүсгэхгүй байх тал дээр анхаарч ажиллаж байгаа хэдий ч төсөв танагдаж ирсэнтэй холбоотойгоор өр үүсч байна.

Байгууллагын 2022 оны төсөв, 2023-2024 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд гарган УБЕГ-т хүргүүлэхээр ажиллаж байна.

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу байгууллагын санхүүгийн мэдээллийг www.shilendans.gov.mn, сайтад сар бүр тогтмол байршуулан 60 удаагийн мэдээлэл шинэчилж, www.bayankhongorburtgel.com сайтад тогтмол байршуулан 5 удаагийн мэдээлэл шинэчилж ажилласан.

2020 оны Санхүүгийн тайлан, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Төрийн Аудитын байгууллагаар шалгагдаж ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажиллаж “Зөрчилгүй” санал дүгнэл авсан болно.

Нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 7.609.1, түлш халаалтын зардалд 5.882.7, бичиг хэргийн зардалд 1.220.4, хог хаягдлын зардалд 199.0, шатахууны зардалд 198.3 нийт 15.109.6 мянган төгрөгийн өртэй байна.

ЕС. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАХ АЖИЛЛАГАА

9.1. Байгууллагаас зохион байгуулсан ажил, үйлчилгээ

Хэлтсийн цахим вэйб хуудсанд 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар цаг үеийн мэдээ мэдээлэл, мэдээллийн ил тод байдлыг ханган bayankhongor.burtgel.gov.mn гэсэн цахим хуудсанд 77 үйл ажиллагааг сурталчлан байршуулсан. Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс гэсэн пэйж хуудсанд 17 удаагийн мэдээ мэдээллийг тавьж байршуулан иргэд олон нийтэд сурталчилж ажилласан байна.

Хэлтсийн албан хаагчдад УБЕГ болон хэлтсээс зохион байгуулсан ажил үйлчилгээ, орон нутгийн төр захиргааны байгууллагын бодлого шийдвэрийг сурталчлахад идэвхтэй оролцон холбогдох цахим хаягуудад хандалт хийж, шэйр хийж хөл хорио тогтоосон онцгой дэглэмийн үед идэвхтэй ажиллах үүргийг өгч гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ болгон тусган хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Орон нутгийн “Hongor TV” телевиз болон аймгийн Төв талбайн дэргэдэх лейд дэлгэцээр УБЕГ-ын сайтад байршуулсан Сонгогчийн нэрийн жагсаалтаас өөрийн мэдээллийг шалгах шторкийг цацуулж олон нийтэд түгээсэн.

9.2. Байгууллагын архив, бичиг хэргийн эргэлтийн бүртгэл, тайлан

Хэлтсийн хэмжээнд 2021 оны 06 дугаар сарын 15-ны байдлаар ирсэн албан бичиг **423**, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаал 14, чиглэл, зөвлөмж 15, дотоод албан бичиг 4 нийт 33 албан бичиг тус тус бүртгэгдсэн байх ба хэлтсээс 478 албан бичиг явуулсан байна.

Ирсэн, явсан албан бичиг болон өргөдөл, гомдлыг скайнердэж **Able** программ дээр бүртгэн хяналтын карт хөтлөн хяналт тавин ажиллаж байна.

Хэлтэст нийт 290 **хариутай албан бичиг ирүүлсэн ба** хуулийн хугацаа хэтрүүлэн хариу илгээсэн албан бичиг байхгүй болно.

Удирдлагаас гарах шийдвэрийн болоод зохион байгуулалтын баримт бичиг буюу Хэлтсийн даргын тушаал 6, хамт олны хурлын тэмдэглэл **2** гарсан байна.

2021 оны байгууллагын “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-д тусгуулах шаардлагатай Бүртгэлийн үйл ажиллагааны явцад шинээр бий болсон баримт материалын нэрийн саналыг албан хаагч тус бүрээс авч бүрэн тусгуулав.

Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Тайлант хугацаанд хэлтсийн хэмжээнд /2021.01.02-2021.06.15 хүртэл/ нийт 71 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн байх ба үүнээс шийдвэрлэгдсэн 47, хугацаа болоогүй 24, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй байна.

Мөн ирсэн өргөдөл, гомдлыг **Able** программ дээр болон өргөдөл, гомдлын дэвтэр дээр бүртгэн хяналтын картыг хөтлөж байна.

Өргөдлийг агуулгаар нь авч үзвэл лавлагаа мэдээлэл болон архивын үйл ажиллагаатай холбоотой 1, ЭХЭУБ-ийн үйл ажиллагаатай холбоотой 4, бүртгэлийн хяналтын үйл ажиллагаатай холбоотой 52, албан хаагчийн нийгмийн асуудал болон хүний нөөцийн асуудлаар 14 өргөдөл бүртгэгдсэн байна.

Өргөдөл, гомдлын мэдээг улирал бүрийн сүүлийн сарын 20-нд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газарт хүргүүлж, хэлтсийн цахим хуудсын холбогдох цэст байршуулан ажиллаж байна.

АРАВ. БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДИЙН СУРГАЛТ, ХӨГЖИЛ, ЁС ЗҮЙ

10.1. Албан хаагчдын сургалт, хөгжил

Байгууллагын нийт албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хэлтэс нь сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг хагас бүтэн жилээр батлан хэрэгжүүлж хэвшсэн бөгөөд 2021 оны хагас жилийн байдлаар доорх байдлаар сургалт мэдээллийг ажлыг зохион байгуулж ажилтнуудыг хамрууллаа.

-2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр УБЕГ-ын Тамгын газрын дарга Г.Цолмонгийн баталсан “Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдэвт онлайн сургалтанд хэлтсийн бүх албан хаагчид хамрагдсан.

- 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдөр Баянхонгор аймгийн Архивын тасгийн дарга В.Эрдэнэчимэгийн “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”-ийн талаар мэдээлэл өгөх сургалтанд бүх албан хаагч хамрагдсан.

- 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс Глобал Удирдагч Их сургуулийн Ахисан түвшний сургуулийн магистрын хөтөлбөрт хамрагдан гэрээ байгуулж эрх зүйн магистрын ангид хэлтсийн 9 албан хаагчийг 1,5 жилээр элсэн суралцуулж эхлэв.

- Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газраас зохион байгуулсан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Журам батлах тухай” Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралт, “Стратеги төлөвлөгөө боловсруулах батлах, хэрэгжилтийг хангах журам” мөн оны 217 дугаар тогтоолын хавсралт, “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн

зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам” болон 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-уудыг танилцуулах цахим сургалтанд төрийн захиргааны бүх албан хаагчид 2021 оны 05 дугаар сарын 1-ний дотор хамрагдаж гэрчилгээ авсан.

- Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын “Төрийн албан хаагчдыг 2021 онд сургах сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Төрийн албаны тухай хууль, холбогдох заавар, журам, тушаал”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчын ёс зүйн дүрэм, цаашид анхаарах асуудал” сэдвээр тус тус цахим сургалтанд бүрэн хамрагдсан.

- Аймгийн цагдаагийн газрын цагдаагийн хошууч Г.Анхбаяр “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвээр, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Н.Мэндбаяр, Сэтгэл судлаач Э.Үүрийнтуяа нар “Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбарт хэрэгжиж буй хууль тогтоомж болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” сэдвээр, мэргэжилтэн Б.Даваасүрэн “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сэдвээр тус тус 2021 оны 05 дугаар сарын 11-нд танхимын сургалтанд хэлтсийн албан хаагчид, онлайнаар сумдын улсын бүртгэгч нар хамрагдсан.

- 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Хэлтсийн даргын баталсан 2021 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Сонгогчийн нэрсийн жагсаалт үйлдэх, танилцуулах журам, Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэг, Төрийн албаны тухай хууль, Төрийн захиргаа болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журам, Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйлчилгээний стандарт, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтны ажил үүрэг гэх мэт сэдвээр Хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал, Иргэний бүртгэлийн тасгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Адьяабаяр нар сургалтанд хийсэн.

-Хэлтсийн даргын 2021 оны сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх хүрээнд тусгай хөтөлбөр батлан 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр “Төрийн албан хаагчдаас гэмт хэрэг зөрчилд холбогдож буй өнөөгийн байдал, анхаарах асуудал” сэдэвт Цагдаагийн газрын мэдээлэл, судлагааны мэргэжилтэн цагдаагийн дэслэгч Б.Цээпилмаа, “Харилцаа ба хандлага”, “Бие хүний соёл” сэдэвт БСГ-ын Насан туршийн боловсрол төвөөс

мэргэжилтэн урьж бүх албан хаагчдад танхимын сургалтыг тус тус зохион байгуулав.

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 102 итгэмжлэгдсэн ажилтнуудад эрх зүйн болон мэдээлэл технологийн сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 29-30-ний өдрүүдэд зохион байгуулж илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

10.2. Албан хаагчийн ёс зүйн асуудал

Улсын бүртгэлийн байгууллага нь төрийн үйлчилгээний 70 гаруй хувийг үзүүлдэг, мөн өдөр тутамдаа байнгын ачаалалтай ажилдаг зэрэг ажлын онцлогоос шалтгаалан харилцааны ур чадварыг ямагт эрхэмлэн ажиллаж байна.

Иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг тандах, албан хаагчдын харилцааны хандлагыг өөрчлөх, байгууллагын үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, үйлчилгээний стандартыг мөрдүүлэх зорилгоор үйлчилгээний зааланд санал хүсэлтийн дэвтэр, өргөдөл гомдол хүлээн авах 89191901 утсыг тогтмол ажиллуулж байна.

Өнөөдрийн байдлаар ёс зүйн зөрчлийн талаар ямар нэгэн гомдол ирээгүй байна.

АРАВ НЭГ. ОРОН НУТАГ ДАХЬ ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Баянхонгор аймагт өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргаас малчдынхаа эрсдэлийг хуваалцаж, онд ороход хүндрэлтэй байгаа малыг бүх нийтээрээ тэжээх уриалгыг гаргасан билээ. Уриалгад Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нэгдэж 2021 оны ажлаа 103 бог малыг хүлээн авч тэжээн онд мэнд оруулах халуун сэтгэлийн дэм болсон ажлаар эхлүүлж бүх нийтийн амралтын болон амралтын өдрүүд болох 2021 оны 01 дүгээр сарын 01-02-ны өдрүүдэд гэрээ барьж малаа хүлээн авч тэжээн онд оруулсан. Нийт дундын сангаас 3090000 төгрөг зарцуулсан.



-2021 он гарсаар ковид 19 цар тахлын хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор аймаг, сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг ханган Хэлтсийн даргаас эргүүл хийх 2 удаагийн хуваарийг батлан 2021 оны 04 дүгээр сарын 10-наас 04 дүгээр сарын 25, 2021 оны 04 дүгээр сарын 26-наас 05 дугаар сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийг хэлтсийн албан хаагчид гүйцэтгэж ажиллалаа.



-МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Бүх нийтээр мод тарих өдрөөр Байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах, ажлын байрны орчны тохижилт үйлчилгээг хийх зорилгоор хэлтсийн албан байр орчмын хог цэвэрлэгээг хийж хэлтсийн гаднах цэцгийн мандалд цэцгийн үр суулгаж, шинээр зүлэгжүүлэлт хийн, байгууллагын хариуцсан ойн зурвас бүхий газарт тарьсан модыг арчлах, услах ажлыг хийж гүйцэтгэсэн.

- Баянхонгор сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 1/146 тоот албан бичгээр Бүх нийтээр мод тарих өдрийг угтан Түйн голын дагуух ногоон зурвасны хайс, хамгаалалтыг сайжруулах, тарьсан модондоо цэнэг усалгаа хийх, амьдрах чадваргүй модны нүхийг дахин сэргээж, суулгац суулгахад бэлтгэх, харалдаа гудамнаас түйн гол хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2021 оны 05 дугаар сарын 09-ны өдөр хийж гүйцэтгэсэн.



-Дэлхийн хэмжээнд тархаад байгаа Covid-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд хэлтсээс ажлын байрны гаднах орчин, өрөө тасалгаа болон үйлчилгээний зааланд ариутгал халдваргүйтгэлийн ажиллагааг Аймгийн МХГ-аас баталсан хуваарийн дагуу “Акос” ХХК-аар 4 удаа, Хэлтсийн 1 албан хаагч ковид-19 халдвар авсантай холбоотойгоор ЗООНОЗ судлалын төвөөр тус тус чанарын шаардлага хангасан ариутгалын бодисоор гүйцэтгүүлэн ажиллалаа.



Хэлтсээс зохион байгуулсан бусад ажил

2021 оны 03 дугаар сарын 16-ны өдөр УБЕГ-аас Жендэрийн үндэсний хорооноос “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан “Би Жендэрийн хэвшмэл байдлын эсрэг байна” уриатай БИ... БАЙНА аяныг 2021 оны 03 дугаар сарын 15-

наас 18-ны өдрүүдэд зохион байгуулсантай холбогдуулан БИ ... БАЙНА аяны лого бүхий зургийн хүрээгээр фэйсбүүк пэйж хуудсынхаа нүүр зургаа бүх албан хаагчид сольж уг аяныг дэмжин илтгэх хуудсыг хүргүүлсэн.

- 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Төрийн албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаанд бүх албан хаагчдын бүрэн хамруулсан.

- **Аймгийн ЭМГ-т албан бичгээр хүсэлт хүргүүлж** Коронавирус буюу Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулж байгаа урьдчилан сэргийлэх тарилгын 1,2-р тунд бүх албан хаагчдыг бүрэн хамруулах арга хэмжээг авсан.

- Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу хэлтсийн дарга оройн 20.00-23.00 цагт “Пост 3” дугаар цэгт эргүүлийн үүргийг гүйцэтгэж ажилласан.

- Аймгийн ЗДТГ-аас 7 хоног бүрийн Мягмар гарагт зохион байгуулдаг шуурхайд тухай бүр нь оролцож хэлтсийн албан хаагчдыг мэдээ мэдээллээр хангаж ажиллав.

- Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс 3 сард зохион байгуулсан төрийн албан хаагчийн шалгалтын комисст ажиллан, шалгалтанд оролцогчдын мэдээллийг хурууны хээгээр шалган оруулж хамтран ажилласан.

- Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Гэр бүлийн үнэ цэнэ” өдөрлөгт 2021 оны 05 дугаар сарын 14-нд хэлтсээс нэг гэр бүлийг оролцуулж сургалтанд хамруулсан.

- Хэлтсийн дарга МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаанд аймгийн Сонгуулийн хорооны гишүүнээр ажиллаж сонгуулийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж явуулсан.

- Хэлтсийн Үйлдвэрчний эвлэлийн хорооноос бүх албан хаагчиддаа 2 удаа маск, витамин, амин дэмийг олгож дэмжлэг үзүүлсэн. Мөн “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан албан хаагч бүрт 2 хүүхдийн бэлгийг тус бүр 15250 төгрөгийн үнэтэй 82 ширхэгийг 1250500 төгрөгөөр худалдан авч албан хаагчдын хүүхдүүдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

-Байгууллагын албан хаагчдын дундын сангаас хүндээр өвчилсөн ажилтан түүний гэр бүлд тус тус 200,000, нийт 800,000 төгрөгийн тусламж олгосон байна. Мөн эрүүл мэндийн шалтгаанаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 5 албан хаагч тус бүрт эргэлтийн 30,000 төгрөгийг олгосон.

- Хэлтсээс сайн үйлсийн аянд нэгдэж аймгийн Онцгой байдлын газрын ажилтан Б.Ганболдын хүүхдийн хагалгаанд 150,000 төгрөгийн хандив өргөсөн.

- "Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн Манлайллын хөтөлбөр"-ийн цахим сургалт болон төгсөлтийн баярт 5-р сарын 18-ны 10:00 – 12:00 цагийн хооронд /Zoom/ програм ашиглан цахимаар зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсон.

- Аймгийн Засаг даргад 2021 оны 2 дугаар сарын 10-ны 1/125 тоот хүсэлт хүргүүлэх тухай албан тоотоор хэлтсээс эрх зүйч мэргэжлээр суралцаж буй албан хаагчдын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх болон хэлтсийн албан хэрэгцээнд автомашин шийдвэрлэж өгөх хүсэлтүүдийг тус тус хүргүүлэн ажиллалаа.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг баримтлан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Хэлтсийн албан хаагч, сумдын улсын бүртгэгч нараар дамжуулан бүрэн эрхээ хэрэгжүүлж, 2021 оны үндсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг хангах талаар

1.1. Бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэлийг даруй шийдвэрлэх

2. Албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшсэн тогтвортой байлгах талаар

2.1. Улсын бүртгэгч нарыг туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтанд өргөн хамруулах;

1.2. 2021 он гарсаар хүргүүлсэн холбогдох журманд заасан болзол хангасан ажилтнуудын зэрэг дэвийн нэмэгдлийг шийдвэрлэх

1.3. Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний онцлогоос шалтгаалан бусад төрийн захиргааны албан хаагчдаас илүү цагаар ажилладаг, ачаалалтай байдагт дүгнэлт хийн нийгмийн хамгаалал, тусламж, дэмжлэгийн асуудлыг шийдвэрлүүлэх ;

1.4. Ковид 19 өвчнөөр өвдсөн албан хаагчид тусламж үзүүлэх асуудлыг шийдвэрлэх

Эдгээр саналыг анхааран шийдвэрлэх нь байгууллага, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сайжруулах, бүртгэлийн байгууллагын хэвийн ажиллах нөхцөл боломжийг бий болгоход ач холбогдолтой байх болно.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.МӨНХЖАРГАЛ

